

“СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04-р сарын 30-ны өдөр

№1

Улаанбаатар хот

2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДҮГНЭЛТИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг, “Сүү” ХК-ийн 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн №2 тоот “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сүү” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.СОЁЛ-ЭРДЭНЭ

“СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04-р сарын 30-ны өдөр

№2

Улаанбаатар хот

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ ЧӨЛӨӨЛЖ, ТОМИЛОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг, “Сүү” ХК-ийн дүрмийн 8 дугаар бүлэг болон “Сүү” ХК-ийн 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн №2 тоот Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сүү” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэн эрхийг бүрэн бүрэлдэхүүнээр нь дуусгавар болгосугай.

2. “Сүү” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Ердийн гишүүнээр:

1. Д.Ганбаатар
2. Д.Цэрэнжигмэд
3. Д.Жамъян
4. Ц.Соёл-Эрдэнэ
5. Б.Түвшинтөгс
6. Д.Уянгалянхуа
7. Д.Тунгалаг
8. С.Сүхболд

Хараат бус гишүүнээр:

9. Г.Баяр
10. Ш.Даваалимбэ
11. П.Мэндсайхан
12. Н.Цэрэндорж

ХУРЛЫН ДАРГА



Ц.СОЁЛ-ЭРДЭНЭ

“СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04-р сарын 30-ны өдөр

№3

Улаанбаатар хот

ТУЗ-ИЙН ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг, “Сүү” ХК-ийн дүрмийн 8 дугаар бүлэг болон “Сүү” ХК-ийн 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн №2 тоот Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сүү” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин, урамшууллын хэмжээг дараах байдлаар тогтоож, 2021 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн тоцон олгосугай. Үүнд:

№	Албан тушаал	Тухайн жилд олгох цалин, урамшууллын НИЙТ ХЭМЖЭЭ
1.	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга болон гишүүд	Компанийн жилийн цалингийн зардлын төлөвлөгөөний 2.8%

2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин, урамшууллыг тогтоосон хэмжээгээр, олгохыг Гүйцэтгэх захирал /М.Болод/ болон Санхүүгийн албаны дарга /Э.Уянга/-нд тус тус зөвшөөрсүгэй.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбоотойгоор компанийн “Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Үйл ажиллагааны журам”-д холбогдох өөрчлөлтийг оруулж, нарийвчлан зохицуулахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.СОЁЛ-ЭРДЭНЭ

“СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 04-р сарын 30-ны өдөр

№5

Улаанбаатар хот

“СҮҮ” ХК-ИЙН ДҮРЭМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТОГТООХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг, “Сүү” ХК-ийн дүрмийн 8 дугаар бүлэг болон “Сүү” ХК-ийн 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн №2 тоот Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сүү” ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, компанийн дүрмийн эхийг Хавсралт №1 ёсоор баталсугай.
2. “Сүү” ХК-ийн шинэчилсэн дүрэм холбогдох тогтоол, шийдвэрийг эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг “Сүү” ХК-ийн Гүйцэтгэх захирал /М.Болод/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ц.СОЁЛ-ЭРДЭНЭ

“Сүү” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн
№5 тоот Тогтоолын хавсралт-№1

“СҮҮ” ХК-ИЙН ДҮРЭМД ОРУУЛАХ
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ



№	Одоогийн заалт	Нэмэлт өөрчлөлт орсны дараа
1.	3.2. Компани нь сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, сүүний тээврийн үйлчилгээ болон бусад хуулиар хориглоогүй бүх төрлийн үйл ажиллагаа явуулна.	3.2. Компани нь сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа, сүүний тээврийн үйлчилгээ болон <u>сүүний үхрийн фермерийн аж ахуй, малын тэжээлийн ургамал, хүнсний ногоо тариалах</u> , бусад хуулиар хориглоогүй бүх төрлийн үйл ажиллагаа явуулна.

-----oOo-----